



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 166

Шивээговь сум

“Иргэний танхимын засвар”-ын
ажлын гүйцэтгэлийг хүлээж авах комисс
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.10, Засгийн газрын 2021 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 212 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.12 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2022 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Иргэний танхимын засвар”-ын ажлыг ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга:

Ц.Цэрэндорж

(Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

У.Чулуунцэцэг

(Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Нарийн бичгийн дарга)

Б.Дэлгэрдалай

(Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн)

42122 245

С.Энхцэцэг

(1 дүгээр багийн иргэн)

Нарийн бичгийн дарга:

Ц.Замбага

(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдаа авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн "Иргэний танхимын засвар"-ын ажлыг ашиглалтад оруулах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг комиссын дарга (Ц.Цэрэндорж)-д, өмч хөрөнгийг бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн (Ц.Замбага), нягтлан бодогч (Л.Цэнд-Аюуш) нарт, өмч хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, үр ашгийг дээшлүүлэн, ашиглалт хамгаалалтыг сайжруулахыг ашиглагч байгууллагын дарга (А.Дэлгэрзаяа) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Гүйцэтгэлийн ажлыг захиалагчаас гаргасан ажлын даалгаврын дагуу шаардлагад нийцсэн техникийн үзүүлэлтэд акт үйлдэн холбогдох баримтыг хавсарган хүлээлцэхийг комиссын дарга (Ч.Сугармаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

П.ГАНЧИМЭГ

